



**МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ САЙД**


Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160  
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,  
Цахим шуудан: info@mddc.gov.mn  
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2022.11.25 № 01/2097  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хэрэгжилт хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталж, 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ыг үндэслэн Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн биелэлт, Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтийг тус тус нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт үүгээр хүргүүлж байна.

Хавсралт ..... хуудастай.



Н.УЧРАЛ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын  
2022 оны хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай**

2022.11.25

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго,  
үндэслэл, арга зүй**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Алсын хараа – 2050” хөтөлбөрт туссан арга хэмжээний 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон ҮР ДҮН, НОТЛОХ БАРИМТ-нд тулгуурлах зарчмыг баримталлаа.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

“Алсын хараа – 2050” хөтөлбөрт туссан 54 арга хэмжээний хэрэгжилтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны газар, хэлтэс тус бүр хариуцсан ажил үүрэг, чиглэлийн дагуу тайлагнаж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн  
бодлогын хэрэгжилт /үйл ажиллагааны чиглэлээр/**

№	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэмжээ	Оноогоор	Хэрэгжилт /хувиар/
1	Хүний хөгжил	1	70	70
2	Эдийн Засаг	12	850	70,8
3	Засаглал	22	1990	90,45
4	Амар тайван, аюулгүй нийгэм	19	1450	76,31

**Сайжруулах шаардлагатай арга хэмжээнээс онцлон дурдвал:**

Бодлогын баримт бичгийн Амар тайван, аюулгүй нийгэм хэсгийн 7.5.6-д “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлнэ” гэж төлөвлөсөн ажлын

хүрээнд “Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар бүлэгт цахим мэдээлэл, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдал алдагдах, аюул занал тохиолдох магадлал, эмзэг байдлын түвшин, түүнээс үүсэх үр дагавар, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох мэргэшсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/115, А/104 дугаар хамтарсан тушаалаар Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан журам, дүрмийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлалын төслийг боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн цахим хуудсаар дамжуулан олон нийтээс санал авч байна” гэж тайлагнажээ. Өөрөөр хэлбэл уг ажлын явц боловсруулах шатанд байгаа боловч, 2023 онд Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан журам, дүрмийг боловсруулах бүрэн боломжтой нөхцөл байдалд байгааг онцлох нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын 2050 хүртэлх оны хугацаанд төлөвлөсөн ихэнх суурь ажлууд ахиц дэвшилтэй харагдаж байгаа ч нөгөө талдаа төсөв, санхүүгийн асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас ажлын явц удаашралтай зогсонги байдалд байгааг дурдах нь зүйтэй байна.

### **Гурав. Дүгнэлт**

“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээ, төслүүдийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 80.74 хувьтай дүгнэгдлээ.

1. Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100%-ийн биелэлттэй арга хэмжээ - 20
2. Зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу 90%-ийн биелэлттэй арга хэмжээ – 9, 70%-ийн биелэлттэй арга хэмжээ – 17
3. Зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай буюу 50%-ийн биелэлттэй арга хэмжээ – 6, буюу 30%-ийн биелэлттэй арга хэмжээ – 2 байна.

### **ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**

1. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа ҮР ДҮН, НОТЛОХ БАРИМТ-нд тулгуурлах зарчмыг мэргэжилтэн болон нэгжийн удирдлагууд мөрдлөг болгон ажиллах;

2. Төлөвлөгөөний биелэлт нь тухайн байгууллага, нэгж, ажилтан бүрийн хийсэн ажлын үр дүнг харуулдаг тул хугацаа, агуулгыг анхаарах;

3. Хүрэх түвшний тоон үзүүлэлтийг болон чанарыг өдөр тутмын ажилдаа анхаарах

4. Биелэлтийн хувь бага, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгайлан авч үзэж, тодорхой ажлууд зохион байгуулах;

5. “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг тайлагнахдаа “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг баримт бичгүүд, тэдгээрийг

хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлттэй уялдуулан тайлагнаж хэвших;

6. Мөн газар хэлтсийн дарга нар дотоод зохион байгуулалтаар тайлан төлөвлөгөөг гаргаж хэвших. Цагийн менежментийн талаар тодорхой ойлголттой байж, хуульд заасан хугацааг баримталж ажиллах;

7. Төрийн захиргааны удирдлагын газрын тайлан мэдээ хариуцаж буй албан хаагчид нэгжийн дарга нар эцсийн тайланг, нотлох баримтын хамтаар өгч хэвших,

8. Төлөвлөгөөнд туссан боловч салбарын бусад байгууллагаас хамаарах ажилд анхаарал хандуулж, хамтран ажиллах.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажиллахыг тус тус зөвлөж байна.

## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР